# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (597)

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

- *Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны зургадугаар сарын 24 № 24 (597) Улаанбаатар хот

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

306. Автотээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай 503

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

307. Үндсэн чиглэл батлах тухай Дугаар 38 503
308. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай Дугаар 39 525

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

309. Архангай аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай Дугаар 119 529

### Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

310. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай Дугаар 01 531

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2009 оны 05 дугаар сарын 07-ны өдөр** **Улаанбаатар хот**

### АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Автотээврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд байгалийн шатдаг хий, цахилгаан эх үүсвэрээр ажилладаг автотээврийн хэрэгсэл ашиглана." гэсэн 9.4 дэх хэсэг нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2009 оны 05 дугаар сарын 14-ний өдөр** **Дугаар 38** **Улаанбаатар хот**

### Үндсэн чиглэл батлах тухай

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2. Цаг үеийн зайлшгүй шаардлагатай хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг энэ тогтоолын 1 дэх заалтад заасан үндсэн чиглэлд тусгагдсан эсэхийг харгалзалгүйгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлж байхыг Засгийн газар /С.Баяр/-т үүрэг болгосугай.

3. "Монгол Улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл"-ийн биелэлтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газар /С.Баяр/, холбогдох Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
38 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2012 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага | Төслийн нэр | Хууль санаачлагч | Өргөн мэдүүлэх хугацаа | Хяналт тавих Байнгын хороо |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. Хуулийн төсөл** | | | | | |
| **1. Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулах хуулийн төсөл** | | | | | |
| **Эрүүл мэндийн чиглэлээр:** | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрөөс төлбөрийг нь хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний төрөл, хэлбэрийг орчин үеийн жишигт нийцүүлэн шинэчлэн тогтоох | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 2 | Амралт, сувилал, эмнэлэг, зочид буудал, жуулчны байгууллага болон бассейн, саун, халуун усны зэрэг үйлчилгээ явуулах барилга, байранд тавих эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг нарийвчлан зохицуулах | Ариун цэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 3 | Тамирчид, дасгалжуулагчид, спортын холбоодын хариуцлагын тогтолцоог сайжруулах, биеийн тамир, спортын байгууллагын ажил, үйлчилгээний чанар, хүн амд үйлчлэх тохиромжтой орчин, нөхцөлийг бүрдүүлэх, биеийн тамир, спортын байгууллагуудыг магадлан итгэмжлэх замаар ажлыг нь сайжруулах | Биеийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 4 | Эм бүртгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, аюулгүй, чанартай эм үйлдвэрлэх, импортлох, үйлчлэх эрх зүйн орчныг сайжруулах, эм хангамжийн байгууллагын ангилалд тавигдах шаардлагыг шинэчлэх | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 5 | Монгол Улсын иргэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд аливаа нэг эрхтэнээ өгөхийг хориглох, эрхтэнээ өгөх хүсэлтэй байгаа иргэний тэрхүү боломжийг хангах эрх зүйн харилцааг нарийвчлан зохицуулах | Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 6 | Бүх аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтийн үйлчилгээний газрыг 100 хувь тамхигүй орчин болгохын зэрэгцээ эрүүл мэндийн зурагтай анхааруулга, тамхины хайрцаг, сав, баглаа боодолд тавих шаардлагыг шинэчлэн хуульчлах | Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Сэтгэцийн өвчтэй хүний эрхийг хамгаалахад чиглэсэн зохицуулалтыг тодорхой болгох | Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 8 | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн хяналт, зохицуулалтыг салгах, эмийн санд тусгай зөвшөөрөл олгож байгаа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагаас энэ төрлийн эм олгодог эмийн санг тогтоох, зөвшөөрлийн дагуу хяналт тавих зохицуулалт бий болгох | Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭМЯ/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| **Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр:** | | | | | |
| 9 | Инновацийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх, инновацийн санхүүжилтийн олон хэлбэрийг бий болгох, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн тогтвортой хамтын ажиллагааг дэмжин урамшуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Инновацийн тухай /шинэ/ | Засгийн газар /БСШУЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 10 | Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сангийн тогтолцоог бий болгох, уг санд бүртгэгдсэн мэдээллийн нууцлалыг хадгалах, улс, орон нутгийн хамгаалалтын бүсэд орших түүх, соёлын дурсгалт зүйл, түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хамгаалах, байгалийн гамшиг, цахилгаан эрчим хүчний гэнэтийн тохиолдлоор үүсэх эрсдэлийг нөхөх зорилгоор даатгалд хамруулах тогтолцоог бүрдүүлэх | Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БСШУЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 11 | Соёл, урлагийн байгууллагын удирдлага болон уран бүтээлчдийн ёс зүй, хувьчлалын асуудал болон ном, хэвлэл, цахим бичвэрийн талаархи зохицуулалтыг хуульд тодорхой тусгах | Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БСШУЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 12 | Төрийн болон төрийн өмчийн бус ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ, дүгнэлт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БСШУЯ/ | 2011 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 13 | Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэх | Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БСШУЯ/ | 2011 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| **Нийгмийн хамгааллын чиглэлээр:** | | | | | |
| 14 | Хөдөлмөрийн харилцааны үндсэн асуудлууд болох ажлын цаг, хөдөлмөрийн хөлс, хөдөлмөрийн гэрээ болон хөдөлмөр эрхлэлтийн байдал, нийгмийн баталгаатай холбоотой нэр томъёог оновчтой, нэг мөр, ойлгомжтой болгох, хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /НХХЯ, СЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 15 | Шинээр 3 дахь хүүхдээ төрүүлсэн эхэд мөнгөн урамшуулал олгох эрх зүйн үндсийг бий болгох | Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /НХХЯ, СЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 16 | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг эдийн засгийн салбаруудаар ялгаатай тогтоох, ажил олгогчдын төлбөрийн чадварыг харгалзан хамтын гэрээ хэлэлцээрээр уян хатан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /НХХЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 17 | Гадаадад ажиллах хүч гаргах асуудлыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгох, энэ үйл ажиллагаанд оролцогч талууд, ялангуяа зуучлагчдын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, гадаадаас ажиллах хүч авах асуудлыг өөрийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой зохистой хослуулах зорилгоор эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /НХХЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 18 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулах, арга, механизмыг боловсронгуй болгох | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /НХХЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 19 | Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нэр төрлийг оновчтой болгох, даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, түүнчлэн эрүүл мэндийн давхар даатгалыг хөгжүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /НХХЯ, ЭМЯ/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 20 | Олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бий болгох,тэтгэврийн бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн олон эх үүсвэрийг бий болгох замаар нийгмийн даатгалын тогтолцоог зах зээлийн хөгжилтэй уялдуулах, улсын төсвийн болон нийгмийн даатгалын сангийн санхүүгийн удирдлагыг боловсронгуй болгох, тэтгэврийн доод хэмжээг тогтоодог тогтолцоог цалин хөлсний уялдаанаас салгаж аж ахуйн нэгж, байгууллага, төсвийн эдийн засгийн дарамтыг бууруулах | Нийгмийн даатгалын багц хуулиуд /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /НХХЯ, ЭМЯ/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 21 | Нийгмийн халамжийг хүртэх шаардлагатай иргэдэд хүртээмжтэй хэмжээгээр нь хүргэх, нийгмийн халамжийн давхардлыг арилгаж үр дүнтэй байлгахад чиглүүлэх, нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний нэр төрлийг тодорхой болгох, халамж, асрамжийн үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, үйлчилгээг үзүүлж байгаа байгууллагуудыг магадлан итгэмжлэх тогтолцоог бий болгох | Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /НХХЯ, СЯ/ | 2011 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 22 | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохицуулалтыг сайжруулах, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, тэтгэврийн хуримтлалын сангийн үйл ажиллагааг зохицуулах, боловсронгуй болгох замаар ирээдүйд тэтгэвэр авагчдад олгох тэтгэврийн хөрөнгийн эх үүсвэрийг арвижуулах зэрэг эрх зүйн орчныг бүрдүүлэх | Нийгмийн даатгалын сангийн удирдлага, менежментийн тухай /шинээр/ | Засгийн газар /НХХЯ, СЯ/ | 2011 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| **Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр:** | | | | | |
| 23 | Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн эрх зүйн үндсийг бий болгох, хяналт шалгалтын эрх, үүргийг өргөжүүлэх | Төв банк /Монголбанк/-ны тухай хуульд нэмэлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 24 | Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, түүний санхүүгийн зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний зохицуулалтыг нарийвчлан зохицуулах | Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, ХЗДХЯ, Санхүүгийн зохицуулах хороо/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | Улсын болон бүс нутгийн ач холбогдолтой томоохон төслийг санхүүжүүлэх чадвар бүхий хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах | Хөрөнгө оруулалтын сангийн тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, Санхүүгийн зохицуулах хороо/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 26 | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны арга хэлбэр, зарчим, бизнест төрийн зүгээс учруулдаг дарамт шахалтыг багасгах, шаардлагагүй дүрэм, журмуудыг хүчингүй болгох, зөвшөөрлийн тогтолцооноос бүртгэлийн тогтолцоонд шилжих | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, ХЗДХЯ, ЗТБХБЯ, ЭБЭХЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 27 | Банкны байгууллагын санхүүгийн үйлчилгээний хүрээг өргөтгөн хяналт шалгалтыг нэгдмэл цогц байдлаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх | Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 28 | Эдийн засгийн харьяат хоорондын болон харьяат бустай хийх гадаад валютын аливаа гүйлгээ, гадаад валютын дотоодын захын зохицуулалт, валютын зохицуулалтын талаархи төрийн эрх бүхий байгууллагуудын эрх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой тайлан, мэдээлэл, хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах, гадаад валютын эрх зүйн орчныг өнөөгийн нөхцөлд нийцүүлж, валютын санхүүгийн шинэ хэрэгсэл хэрэглэх | Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 29 | Бүх төрлийн төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх зохицуулалтыг бий болгох | Төгрөгөөр төлбөр тооцоо гүйцэтгэх тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 30 | Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоог бусад хоршооноос тусад нь авч үзэх, тэдгээрийн үйл ажиллагаанд тавигдах нөхцөл, шаардлага, хяналтын тогтолцоог бий болгох, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох зэрэгтэй холбогдсон харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах | Хадгаламж зээлийн хоршооны тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, Санхүүгийн зохицуулах хороо/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 31 | Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, даатгалд хамрагдах хадгаламжийн хэлбэр, хэмжээг тогтоох, хадгаламжийн даатгалын байгууллагыг үүсгэн байгуулах, түүний удирдлага, зохион байгуулалт, эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулах | Иргэдийн мөнгөн хадгаламжийн даатгалын тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 32 | Санхүү, эдийн засгийн итгэлцлийн харилцааг зохицуулах | Итгэлцлийн тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, Монголбанк/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 33 | Хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж төлөвшүүлэх, үнэлгээ хийх үйл ажиллагаанд төрийн байгууллагаас хяналт тавихтай холбогдсон харилцааны эрх зүйн үндсийг тогтоох | Хөрөнгийн үнэлгээчдийн үйл ажиллагааг зохицуулах тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 34 | Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбогдсон асуудлыг нэгдсэн байдлаар нэг мөр зохицуулах бодлогын хүрээнд салбарын хууль тогтоомжид одоо байгаа төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаатай холбоотой зүйл, заалтыг Төрийн албаны тухай хуульд нэг бүлэг болгон нэгтгэж, аливаа тэтгэмж, тусламж, шагнал урамшуулал, нөхөн олговор, хангамж, цалингийн нэмэгдлийн давхардлыг арилгах, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, тооцож бүй үндэслэлийг нэг жишигт нийцүүлэх, хэт ялгавартай тогтоогдсон хөнгөлөлт, тэтгэмж, тусламж, хангамжийг хумих | Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, НХХЯ/ | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | Улсын төсөв өргөжин тэлэхийн хэрээр нэмэгдэж бий болсон орлогыг оновчтой тэгш, шударга зарчмаар хуваарилах, хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох, ирээдүйд тулгарч болох эрсдэлийг бууруулах, төсвийн шинэ бодлого авч хэрэгжүүлэх үүднээс төсвийн удирдлагын шинэчлэлийг хэрэгжүүлэх, түүнийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх | Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай /шинэчилсэн найруулга/, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /СЯ/ | 2010 | Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод |
| 36 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээ оновчтой бус, аж ахуйн нэгж, иргэдийг татвараас зайлсхийх боломжийг олгож байгааг өөрчлөх, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын үнэлгээг эдийн засгийн өнөөгийн түвшинд нийцүүлэн татвар тооцох зохицуулалтыг бий болгох | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 37 | Тендер шалгаруулалтыг үр дүнтэй, түргэн шуурхай зохион байгуулж, тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээг төлөвлөсөн цаг хугацаанд нь хэрэгжүүлэх, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ, ЭМЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 38 | Олон улсын хандивлагч байгууллага, хандивлагч орноос арилжааны нөхцөлтэй зээл авах боломжийг бүрдүүлэх, зээл, тусламжийн нийт мөнгөн дүнгийн хэмжээнээс хамааран зарим зээл, тусламжийг авах эсэх асуудлыг Засгийн газар дангаараа шийдвэрлэх, түүнчлэн зээл, тусламжийн зарцуулалтын хяналтын механизмыг сайжруулах | Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 39 | Үнэт цаасны зах зээлийг олон улсын жишигт нийцүүлэн тогтвортой хөгжүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь шинэчлэн сайжруулах | Үнэт цаасны зах зээлийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /СЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 40 | Даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн санг тодорхой тоон үзүүлэлтээр хуульчлан тогтоосныг эдийн засгийн өсөлт болон инфляцийн өөрчлөлттэй уялдуулан зохицуулах эрхийг байгууллагын эрх хэмжээнд хамруулах | Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 41 | Даатгалын үйлчилгээний хөгжлийн олон улсын жишиг, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан заалтын дагуу иргэний амьдралын урт хугацааны даатгалын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх | Амьдралын даатгалын тухай /шинээр/ | Засгийн газар /СЯ, НХХЯ/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 42 | Бүртгэл, аудитын үйл ажиллагаанд оролцогч талууд болох Сангийн яам, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагаа, эрх, үүрэг, уялдаа холбоо, хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах, нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлох, нягтлан бодогчдын эрх ашгийг хамгаалсан эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 43 | Аудитын чанарын хяналтын оновчтой тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг хуульд тусгах, аудитын үйл ажиллагаа эрхлэх компанийн гаргасан буруутай үйл ажиллагаанд тухайн үйл ажиллагаа эрхлэх компанид хариуцлага тооцохоос гадна, тухайн алдааг гаргасан мэргэшсэн нягтлан бодогч, аудиторт хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох, аудитын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн хэлбэрийг тодорхой болгох, аудитын үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болох болзошгүй эрсдэлийг бууруулах үүднээс аудитын компаниудыг заавал даатгалд хамруулах зохицуулалтыг бий болгох | Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /СЯ/ | 2011 | Төсвийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Эрдэс баялаг, эрчим хүчний чиглэлээр:** | | | | | |
| 44 | Хууль бусаар, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг зохион байгуулалтанд оруулах, байгаль орчин бохирдуулсан иргэнд хариуцлага хүлээлгэх, улмаар нэгэнт нийгэмд бий болсон хувиараа ашигт малтмал олборлож байгаа иргэдийг хариуцлагатай уул уурхайн зарчмаар уул уурхайн үйлдвэрлэл эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх | Бичил уурхайн тухай /шинээр/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 45 | Хийн хангамжийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангах, хийн хангамжийн ажил, үйлчилгээ эрхлэлтийг оновчтой, тодорхой болгох, аюулгүй ажиллагааны хариуцлагыг өндөрсгөх болон үйлдвэрлэл, ахуйд хийг ашиглах зах зээлийг нээх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хийн түлшний салбарт төр, иргэн, хуулийн этгээдийн оролцоо, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг хуулиар зохицуулах | Хийн хангамжийн тухай /шинээр/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 46 | Ашигт малтмалын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд нь бүхэлдээ төрийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэн тодорхой болгож эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлэх, тусгай зөвшөөрлийн бүртгэлийг ил тод, эмх цэгцтэй болгоход чиглэгдэх | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 47 | Ураны судалгаа, хайгуул, олборлолт, баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэртэй болох | Ураны тухай /шинээр/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 48 | Дагаж мөрдөж байгаа Газрын хэвлийн тухай хуулийн зарим заалт нь Ашигт малтмалын тухай хуулийн зүйл, заалттай зөрчилдөж байгаа тул тэдгээрийг Ашигт малтмалын тухай хуультай нийцүүлэх зорилгоор уг хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах | Газрын хэвлийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 49 | Эрчим хүчний зохистой хэрэглээг зохицуулах, үр ашиггүй зарцуулалтыг бууруулах, эрчим хүчийг үр ашигтай хэрэглэх, түүнд төрийн байгууллагын зүгээс хяналт тавих, дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулах | Эрчим хүчний хэмнэлтийн тухай /шинээр/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 50 | 1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн зарим заалт нь шинээр болон шинэчлэн батлагдсан хуулиудтай зөрчилдөж байгаа тул хуулиудын хоорондын уялдааг хангах зорилгоор уг хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах | Газрын тосны тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 51 | Газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, худалдах, үйлдвэрлэх, уг бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 52 | Эрчим хүчний хэрэглээ, эрэлтийг хангах, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох, энэ салбарыг арилжааны хэлбэрт оруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтыг боловсронгуй болгох | Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЭБЭХЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр:** | | | | | |
| 53 | Бэлчээрийн газрыг зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах менежментийг боловсронгуй болгох, бэлчээрийг /өвөлжөө, хаваржааны газар/ малчдын бүлэг, нөхөрлөлөөр дамжуулан хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Бэлчээрийн тухай /шинээр/ | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 54 | Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах, хүнс үйлдвэрлэх, импортлоход тавих шаардлага, хяналтыг боловсронгуй болгох | Хүнсний тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 55 | Тариалан эрхлэгчдэд үйлдвэрлэлээ өргөтгөх, эрчимжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчныг бүрдүүлэх, тариаланчдад гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайд урамшуулал олгох тогтолцоог бүрдүүлэх | Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 56 | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдал, түүнд тавих шаардлага, хамрах хүрээ, зохион байгуулалт зэрэгтэй холбогдсон асуудлыг нарийвчлан зохицуулах болон паркийн газрыг тогтоох, түүний эзэмшлийн асуудлыг тодорхой болгох | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай /шинээр/ | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 57 | Технологи дамжуулах эрх зүйн орчныг шинэчлэх, технологийн аюулгүй байдлыг хангах, технологийн түвшний үнэлгээ хийх тогтолцоо бүрдүүлэх | Технологи дамжуулах тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 58 | Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэлийн тогтолцоог оновчтой болгох, түүхий эдийг стандартын дагуу бэлтгэх, улмаар эцсийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бий болгох | Түүхий эд бэлтгэлийн зохицуулалтын тухай /Биржийн тухай/ /шинээр/ | Засгийн газар /ХХААХҮЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| **Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр:** | | | | | |
| 59 | Шинэ хотхон, хороолол, цогцолборын орон сууц, түүний дэд бүтцийг барьж байгуулах, ашиглалт, үйлчилгээг хариуцах асуудлыг хуульчлах, орон сууцны фондыг нэмэгдүүлэх, хот байгуулалтын бодлогыг хэрэгжүүлэх, хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 60 | Хот, суурины хэрэглэгчдийг цэвэр усаар хангах, усыг ариг гамтай ашиглах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, инженерийн барилга байгууламжийг ашиглах харилцааг боловсронгуй болгох, цэвэр, бохир усны хангагч болон хэрэглэгчийн хоорондын харилцааг зохицуулах, усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоох | Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 61 | Орчин үеийн шаардлагад нийцэхгүй болсон дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ, орон сууцыг шинэчлэн өөрчлөх, хот төлөвлөлт, газар ашиглалт, барилгажилт, тохижилтын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, тэдгээрийн оролцоотой хяналтын тогтолцоог бий болгох, хүн амьдрахыг хориглосон болон хүн амьдрах нөхцөл хангахгүй болсон барилга эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл хангахгүй болсон барилга байгууламжуудыг дахин төлөвлөх, нэг талаас оршин суугчдын эрх ашиг, нөгөө талаас хотын өнгө үзэмжийг дээшлүүлэх эрх зүйн орчныг бий болгох | Хотыг дахин хөгжүүлэх тухай /шинээр/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 62 | Архитектурын үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, захиалагч, барилга угсралтын байгууллага болон архитектурын байгууламжийн эзэмшигчийн эрх, үүрэг болон хүлээлгэх хариуцлагыг тогтоох, архитектурын бүтээлийн буюу зураг төслийн зохиогчийн эрхийг санаачлан боловсруулсан этгээдэд олгох, түүний зөвшөөрөлгүйгээр тухайн барилга байгууламжийн гадна дизайн, төлөвлөлтөд ямар нэгэн өөрчлөлт хийх, эсхүл өөр зориулалтаар бусдад шилжүүлэн ашиглахыг хориглох, захиалагч, зохион бүтээгч, гүйцэтгэгч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах | Архитектурын үйл ажиллагааны тухай /шинээр/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 63 | Химийн хорт болон аюултай бодисыг хот хооронд болон хотын дотор тээвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлж, тээвэрлэлтийн аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах | Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 64 | Газар олгох үйл ажиллагаа болон Засаг дарга нарын эрхийг тодорхой зааж, зохих зөвшөөрөлгүйгээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр дур мэдэн эзэмшсэн бол уг газрыг албадан чөлөөлөх эрх зүйн үндсийг бий болгох, бэлчээр, хадлан, тариалангийн газрын зохицуулалтыг боловсронгуй болгох, газар ашиглалтын хэлбэрээс нь хамааруулан газар эзэмших зориулалтуудыг хуульчлах | Газрын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 65 | Газрын төлбөрийг хэн, ямар хувиар ногдуулах, хураах, хяналт тавих, маргааныг хянан шийдвэрлэх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашиглаж байгаа зарим иргэн, хуулийн этгээдийг газрын төлбөрөөс тодорхой хувиар хөнгөлөх, чөлөөлөх зэрэг асуудлыг нарийвчлан зохицуулах | Газрын төлбөрийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗТБХБЯ, ХХААХҮЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 66 | Хилийн шугамыг цэгийн солбицлоор тогтоож баталгаажуулах, төсвийн хөрөнгөөр худалдан авах ажил, тусгай зөвшөөрлийн асуудлыг нарийвчлан зохицуулах, нийтийн хэрэглээний газрын зураг, атласыг геодези, зураг зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд байгаа мэдээлэлд үндэслэн хэвлэдэг байх, хэмжилтийн багаж, тоног төхөөрөмжийг заавал баталгаажуулах, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулах | Геодези, зураг зүйн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 67 | Иргэний нисэхийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх | Иргэний нисэхийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 68 | Иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба нь аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтаас ангид байх зарчмуудыг хэрэгжүүлэх | Иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах тухай /шинээр/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 69 | Авто замын арчлалт, хамгаалалтыг тогтмол гүйцэтгэх, замын засвар, арчлалтын хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, зураг төсөл зохиох, урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, барилгын хяналт /магадлал/ тавих зэрэг зөвлөхийн үйлчилгээгээр хангах, норм, нормативыг боловсруулах, батлах, тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулах, зам барилгын материалын үйлдвэрлэл зэрэг асуудлуудыг зохицуулах | Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 70 | Газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх, түүнд хяналт тавих, газрын кадастрын үйл ажиллагааг тодорхойлсноор газрын кадастрын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болох газрын нэгдмэл сангийн тоо бүртгэл, газрын улсын бүртгэл, газрын үнэ, үнэлгээ, төлбөр, татварын бүртгэлийн үйл ажиллагааг зохицуулах, мөн засаг захиргааны хилийн цэсийн өөрчлөлтөөс хамааралгүйгээр улсын нийт нутаг дэвсгэрийг бүхэлд нь кадастрын мужлалд хуваах, нэгж талбаруудыг дугаарлаж, бүртгэх тогтолцоог бий болгох | Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 71 | Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээг зах зээлийн үнэд тулгуурлан хийх, газрын төлбөр, татвар ногдуулах, бусдын эзэмшил газрыг нөхөх олговортойгоор буцаан авах болон газрыг хордуулсан, бохирдуулсан тохиолдолд тухайн газрын үнэлгээнд үндэслэн нөхөх олговор олгох, төлбөр, торгууль ногдуулах, даатгал, зээлдүүлэгч, иргэдийг газрын үнийн мэдээллээр хангаж эрсдэлээс хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх | Газрын үнэлгээний тухай /шинээр/ | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| **Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** | | | | | |
| 72 | Байгаль орчны стратегийн үнэлгээг шинээр тусгах, байгаль орчны төрийн хяналтыг сайжруулах, байгалийн баялгийн нөөцийн халдашгүй байдлыг хангах, үүрэг хариуцлагыг чангатгах, зохих шатны Засаг даргын үүргийг тодруулах, орон нутгийн байгаль хамгаалагч, аймгийн байгаль орчны албадын дарга нарын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох | Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 73 | Спорт загасчлал буюу хөвүүрийн загасчлалыг хөгжүүлэх талаар зохицуулах харилцааг тодорхой болгох, ан хийх хугацааг өөрчлөх, агнуурын зориулалтаас эмчилгээний асуудлыг хасах, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах зэрэг зохицуулалтыг тусгах | Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 74 | Ургамлын төлбөрийн хэмжээ хэт бага байгаагаас шалтгаалан ургамлыг их хэмжээгээр түүж ашиглан нөөцийг багасгаж байгаа тул хариуцлагыг чангатгаж, төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх | Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 75 | Байгаль орчны талаархи мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль орчны аудитын тогтолцоог шинээр бий болгох, иргэдэд байгаль орчны асуудлаар маргаан гарвал шүүхэд хандах эрхийг бий болгох | Монгол Улс "Аархус-Конвенци" /Aarhus-Convention/ –д нэгдэн орох тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 76 | Төрөөс тодорхой бодлогын дагуу аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох, аялал жуулчлалын талаар төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгох, аялал жуулчлал эрхлэгчид хүлээлгэх хариуцлагын болон жуулчны аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох | Аялал жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 77 | Байгаль орчныг бохирдуулагчид төлбөр ногдуулж, үүссэн бохирдлыг арилгах санхүүгийн эх үүсвэртэй болох, хохирлыг бохирдлын хэмжээ, төрлөөр нь тооцох эрх зүйн үндсийг бий болгох | Байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлсний төлбөрийн тухай /шинээр/ | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 78 | Агаарыг хамгаалах талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийтлэг эрх, үүргийг тодорхой болгох, байгууллага хоорондын уялдааг хангасан зохицуулалтыг бий болгох, хяналт-шинжилгээний сүлжээний байнгын ажиллагааг хангах, агаарт гаргах бохирдлын зөвшөөрлийн тогтолцоог хуульчлах | Агаарын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 79 | Агаарыг бохирдуулсны хариуцлагын болон агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулахад шаардагдах зардлыг нөхөх сан бүрдүүлэх тогтолцоог бий болгох | Агаарын төлбөрийн тухай /шинээр/ | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 80 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн хурдац, байгаль, цаг уурын эрчимтэй өөрчлөлтийн улмаас байгалийн нөхөн сэргэх процесс алдагдаж байгаа өнөөгийн үйл явцтай зайлшгүй уялдуулан, түүнтэй дасан зохицох асуудлыг тооцоолох үүднээс улс орны хөгжлийн бодлого, хөтөлбөр, бүс нутгийн урт хугацааны төлөвлөгөө, томоохон голуудын сав газарт байгаль орчинд нөлөөлөх байдлын стратегийн болон урьдчилсан үнэлгээ хийх асуудлыг хуульчлах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх явцад олон нийтийн оролцоо, хяналтыг хангах асуудлыг шийдвэрлэх | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 81 | Байгалийн ургамлын хамгаалалтыг сайжруулах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх | Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 82 | Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын менежмент, дотоод бүсчлэл зэрэг ойлголтуудыг шинээр томьёолж, үүнтэй уялдуулж хуулийн зорилтыг тодорхой болгох, байгалийн нөөц, дурсгалт газруудын статусыг дээшлүүлэн улсын төсвөөс санхүүжүүлэх тогтолцоонд шилжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутагт гарч буй зөрчлийг мэдээлсэн иргэдийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх | Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 83 | Нутаг дэвсгэртээ орчны бүсийг байгуулж орчны бүсийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахын зэрэгцээ орчны бүсийн сангийн хөрөнгийг зарцуулах журмыг тогтоож, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүргийг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хариуцуулах, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх | Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 84 | Уул уурхай, үйлдвэржилт хурдацтай хөгжин байгалийн баялаг, ялангуяа усны нөөц ихээр хомсдож байгаатай холбогдуулан ус ашиглалт, хамгаалалт, хяналтыг нэгдсэн байдлаар хуульчлах, иргэдийн оролцоог сайжруулах тогтолцоог бий болгох, хил дамнасан усыг ашиглах, хамгаалах, Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, усны сав газрын зөвлөлийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх | Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БОАЖЯ/ | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| **Хууль зүй, дотоод хэргийн чиглэлээр:** | | | | | |
| 85 | Орон сууцны зээлд хамрагдаж байгаа хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд шаардлагатай мэдээллийг бүрэн өгдөг болох, банк, санхүүгийн байгууллагын хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх | Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 86 | Орон сууцны санхүүжилтийн шинэ арга хэрэгслийг нэвтрүүлэх, ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 87 | Концессийн гэрээний үндсэн дээр төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг эзэмшүүлж, ашиглуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Концессийн тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 88 | Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх төрийн захиргааны байгууллагын тогтолцоог боловсронгуй болгох, шинээр бий болсон харилцааг зохицуулж, хуулийг бүхэлд нь өөрчлөн найруулах | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 89 | Хоёрдмол харьяаллыг хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрөх талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ, ГХЯ/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 90 | Төрөөс иргэнийхээ өмнө хүлээсэн хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг хэрэгжүүлэх зорилгоор нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын улмаас хохирсон этгээдийн хохирлын зохих хэсгийг төрөөс нөхөн олговор хэлбэрээр олгох | Хохирогчид нөхөн олговор олгох тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 91 | Цагдаагийн байгууллагын тогтолцоо, удирдлага, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хамгаалан ажиллах зохицуулалтыг шинээр тусгах | Цагдаагийн байгууллагын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 92 | Шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагааны арга, хэлбэр, шинжилгээний төрлүүд болон шүүхийн шинжилгээ хийх байгууллага, шинжээчийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Шүүхийн шинжилгээний тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 93 | Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хэлбэрийг тодорхой болгох, өмгөөлөгчдийн сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, өмгөөлөгчид болон Монголын өмгөөлөгчдийн холбооны ажлын уялдаа холбоог сайжруулах, төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх тусгай сан бий болгох | Өмгөөллийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 94 | Зарим төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид нөхөн олговор олгох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 95 | Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхой болгох, ойлгомжгүй болон оновчгүй хэрэглэсэн нэр томъёог залруулах, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид нийцүүлэх, албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 96 | Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг шуурхай явуулахын тулд байцаан шийтгэх ажиллагаа явуулах байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн тоог нэмэгдүүлэх | Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 97 | Хуулийн төслийн боловсруулалтын чанар, үр нөлөөг сайжруулах зорилгоор хуулийн төсөл боловсруулах ажиллагааг нарийвчлан зохицуулах, төрийн байгууллагуудын эрх, үүргийг тодорхой болгох, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 98 | Автотээврийн хэрэгслийн жолоочийг хариуцлагын даатгалд хамруулах замаар автотээврийн ослыг багасгах, хохирсон иргэнд нөхөн төлбөр олгоход чиглэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх | Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 99 | Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан торгуулийг бэлэн бус хэлбэрээр ногдуулах тогтолцоог бүрдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, торгуулийн хэмжээг зохистойгоор нэмэгдүүлэх чиглэлээр өөрчлөлт оруулах | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 100 | Спирт, бүх төрлийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг дуудлага худалдаагаар олгодог болох, спиртийн болон бусад согтууруулах ундааны үйлдвэрлэл, хуваарилалт, олголтод Засгийн газар онцгой хяналт тавих, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхэд тавих хяналтын тогтолцоог хуульчлан зохицуулах | Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах, түүгээр үйлчлэх тухай /Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 101 | Нийтэд худалдах зориулалттай галт зэвсэг, сумны импорт, борлуулалт, хэрэглээг нарийвчлан зохицуулах, сум, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисын импорт, борлуулалтыг төвлөрүүлэн тэдгээрийн эргэлтэд тавих хяналтыг чангатгах, галт зэвсэг эзэмшигч иргэдийн хариуцлагыг сайжруулах | Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ, БХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 102 | Арбитрын маргаан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох, арбитрын тогтолцоог сайжруулах, арбитр, шүүхийн хоорондын харилцааг нарийвчлан зохицуулах | Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 103 | Хуульд заасан үндсэн болон журамт үүргээ биелүүлэхгүй байгаа эцэг, эхэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох, гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх, үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг хуульчлан зохицуулах | Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ, НХХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 104 | Нотариатын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгож, нотариатчийн үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлж олон улсын жишигт нийцүүлэх | Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 105 | Дампуурлын ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, дампуурсанд тооцох шалгуурыг нэмэгдүүлэх, дампуурлын ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг нарийвчлан тогтоох, хуулийн зүйл, заалтын агуулгыг тодорхой болгох, нэр томъёо, үг хэллэгийг жигдлэх зэргээр бүхэлд нь өөрчлөн найруулах | Дампуурлын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн болон Эдийн засгийн байнгын хороод |
| 106 | Ашгийн бус хуулийн этгээдийн эрх зүйн байдал, нийгмийн эрх ашгийн төлөө үйлчилдэг байгууллагын статусыг тодорхойлох | Ашгийн бус хуулийн этгээдийн тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 107 | Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг баталгаажуулан хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Хэвлэлийн эрх чөлөөний тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 108 | Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, ялтныг нийгэмшүүлэх ажиллагааг өргөжүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай, боловсронгуй болгох | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2010 | Хууль зүйн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 109 | Захиргааны хариуцлагын тухай хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулах | Захиргааны хариуцлагын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2011 | Хууль зүйн байнгын хороо |
| 110 | Хөдлөх эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах хоёр дахь эх сурвалж болгон барьцаалах, барьцааг бүртгэх, барьцааны шаардлагыг хангах зохицуулалтыг бий болгох | Хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2011 | Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороод |
| 111 | Садар самуун явдалтай тэмцэх ажлын хамрах хүрээг өргөтгөж, зохион байгуулалт, арга зүйн хувьд сайжруулах, энэ ажлыг хариуцах байгууллагын чиг үүргийг тодорхой болгох замаар садар самуун явдалтай үр нөлөөтэй тэмцэх | Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2011 | Хууль зүйн байнгын хороо |
| 112 | Гэрчийг хамгаалах талаар олон улсын жишигт нийцсэн зохицуулалтыг бий болгох | Гэрч, хохирогчийг хамгаалах тухай /шинээр/ | Засгийн газар /ХЗДХЯ/ | 2011 | Хууль зүйн байнгын хороо |
| **Гадаад харилцааны чиглэлээр:** | | | | | |
| 113 | Импортын барааны өсөлт дотоодын үйлдвэрлэгч, хэрэглэгчийн эрх ашигт шууд нөлөөлөх боломжтой тул тэдгээрийг хамгаалах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Худалдааны хамгаалалтын тухай /шинээр/ | Засгийн газар /ГХЯ, ХХААХҮЯ/ | 2011 | Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 114 | Худалдаа эрхлэгчдийг мэргэшүүлэх, хүнс, өргөн хэрэглээний барааны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, гадаад, дотоод худалдааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Худалдааны зохицуулалтын тухай /шинээр/ | Засгийн газар /ГХЯ, ХХААХҮЯ/ | 2011 | Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 115 | Худалдааны салбарт аль нэг улсын монополи бий болох, барааны демпинг хийхээс урьдчилан сэргийлэх, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Демпингийн эсрэг хуулийг гаргаж, эрх зүйн орчныг бүрдүүлэх | Демпингийн эсрэг хууль /шинээр/ | Засгийн газар /ГХЯ, ХХААХҮЯ/ | 2011 | Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод |
| 116 | Олон талт болон хоёр талт олон улсын гэрээг байгуулах талаар хэлэлцээ хийх, байгуулах, батлуулах процедурыг ялгавартайгаар хуульчлан тогтоох, олон улсын гэрээг орчуулах, хэвлэх зэрэг харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох, заавал соёрхон батлах гэрээний төрлийг шинэчлэх | Олон улсын гэрээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ГХЯ/ | 2011 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Батлан хамгаалах чиглэлээр:** | | | | | |
| 117 | Батлан хамгаалах тухай хуулийг аюулгүй байдлын шинэ орчин, нөхцөл дэх улс орны батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн боловсронгуй болгох, орон нутгийн хамгаалалтын үндсийг бий болгох, орон нутгийн хамгаалалтын талаархи Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн чиг үүргийг хуульчлах, цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах түвшинд Улсын Их Хурал болон Засгийн газрын бүрэн эрхийн давхардлыг арилгах | Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БХЯ/ | 2010 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 118 | Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож олон талт үүрэг гүйцэтгэх чадавхийг нэмэгдүүлэх | Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БХЯ/ | 2010 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 119 | Улс орны дайны байдлын үеийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах, тодотгох, хэрэгжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах асуудлуудын уялдаа холбоог төгөлдөржүүлэх | Дайны байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /БХЯ/ | 2010 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| **Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын чиглэлээр:** | | | | | |
| 120 | Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа болон террорист үйлдлийн хор уршиг, хохирлыг арилгахад оролцох үүрэг бүхий тусгай томилгоот анги, салбар, нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох | Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗГХЭГ/ | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 121 | Тагнуулын ерөнхий газрын үндсэн чиг үүрэгт нийцүүлэн эрх зүйн орчин, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хүний нөөцийг бэхжүүлэх арга хэмжээ авах | Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗГХЭГ/ | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 122 | Гүйцэтгэх ажлын болон холбооны техникийн шинэчлэлийг бүртгэл, мэдээллийн тогтолцоог төгөлдөршүүлэх зорилт, мэдээлэл, харилцааны технологийн хөгжилтэй уялдуулан гүнзгийрүүлэх зохицуулалтыг бий болгох | Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗГХЭГ/ | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 123 | Харилцаа холбооны салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /ЗГХЭГ/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| **Монгол Улсын Тэргүүн Шадар сайдын эрхлэх асуудлын чиглэлээр:** | | | | | |
| 124 | Шударга өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, өрсөлдөөний тухай ойлголт, соёлыг нийгмийн сэтгэл зүйд төлөвшүүлж зах зээлийн өрсөлдөөний орчныг бүрдүүлэх | Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /Тэргүүн Шадар сайд/ | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 125 | Итгэмжлэлийн өнөөгийн тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож нэгдсэн зохицуулалтаар хангах, олон талын хэлэлцээрийг биелүүлэхтэй холбогдсон нөхцөлийг бүрдүүлэх, итгэмжлэл, тохирлын үнэлгээний субъектүүдийн харилцааг зохицуулах, улмаар олон улсын жишигт нийцүүлэх | Итгэмжлэлийн тухай /шинээр/ | Засгийн газар /Тэргүүн Шадар сайд/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 126 | Стандартчилал, тохирол, итгэмжлэлийн талаарх ойлголт, нэр томъёо, тодорхойлолтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, итгэмжлэл, тохирлын субъектүүдийн харилцаа, эрх, чиг үүргүүдийг зааглан нарийвчлан хуульчлах, экологийн цэвэр бүтээгдэхүүн, үйлчилгээг тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын арга механизмтай уялдуулах | Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /Тэргүүн Шадар сайд/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 127 | Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгох, уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах төрийн захиргааны байгууллагын ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /Тэргүүн Шадар сайд/ | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 128 | Уламжлалт мэдлэг, соёлын бүтээлийг үнэ төлбөргүйгээр хэн дуртай этгээд өөрийн санаа зорилгоор гүйвуулан ашиглах явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаатай холбоотойгоор уламжлалт мэдлэг, уламжлалт соёлын бүтээлийг хамгаалах зохицуулалтыг бий болгох | Уламжлалт мэдлэгийг хамгаалах тухай /шинээр/ | Засгийн газар /Тэргүүн Шадар сайд/ | 2011 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Хууль зүйн байнгын хороод |
| **Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын чиглэлээр:** | | | | | |
| 129 | Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг боловсронгуй болгон удирдлагын зүй зохистой тогтолцоог бүрдүүлж олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, улсын байцаагчийн нийгмийн баталгааг хангах | Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /Шадар сайд/ | 2009 | Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хороод |
| 130 | Хүн, малын гоц халдварт өвчин, химийн хорт бодис, гамшиг, ослын улмаас учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй шуурхай арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үүднээс хүн хүч, техникийг дайчлах зохицуулалтыг бий болгох | Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /Шадар сайд/ | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 131 | Хүний эрхийн Үндэсний Комиссын бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагууд төлөөллөө сонгож оруулдаг байх, уг Комисст хүүхдийн эрхийн асуудал хариуцсан гишүүн ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, хүний эрхийг хангах, хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн мэдлэгийг сайжруулах, өөрийгөө хамгаалах чадварыг хөгжүүлэхтэй холбогдсон эрх зүйн орчныг бүрдүүлэх | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Засгийн газар /Шадар сайд/ | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 132 | Хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах байдалд өртөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, үйлчилгээний төрөл, хэлбэрийг олшруулах, арга механизмыг тодорхойлох | Хүүхэд хамгааллын тухай /шинээр/ | Засгийн газар /Шадар сайд/ | 2010 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| **Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын чиглэлээр:** | | | | | |
| 133 | Нийслэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Нийслэлийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/ | Засгийн газар /ЗГХЭГ/ | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлах хуулийн төсөл** | | | | | |
| 134 | Төрийн албанд иргэдийн итгэх итгэлийг дээшлүүлэх, авлигыг арилгах, албан хаагчийн үйл ажиллагааг ил тод болгож хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах эрх зүйн орчныг бүрдүүлэх | Төрийн албанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай /шинээр/ | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 135 | Бүх шатны шүүхийн шүүгчдийг хөндлөнгийн болон шүүхийн дотоодын тогтолцооны нөлөөнөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлэх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны хараат бус, бие даасан байдлыг хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 136 | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэн, байгууллагын хүлээх үүргийг тодорхой болгох, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, санхүүжилтийг тодорхой болгох | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 137 | Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх шат дамжлагыг багасгаж, өргөдөл гаргагчид учирч буй чирэгдэл, бэрхшээлийг арилган өргөдөл, гомдол шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгож хариуцлагыг дээшлүүлэх | Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2010 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 138 | Төрийн цэргийн байгууллагуудад цэргийн хэргийн шаардлагатай асуудлаар нэгдмэл хэм хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд тогтоож мөрдүүлэх, хугацаат цэргийн алба хаагчид цэргийн зохих мэргэжил эзэмшүүлэх сургалтын үндсэн агуулгыг хуульчлан тогтоох | Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2010 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 139 | Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, хувь нийлүүлэгчдийн хурлын эрх, үүргийг тодорхой болгож жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг бий болгох | Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 140 | Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэн, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох /Энэ хуультай холбогдуулан Иргэний бүртгэлийн тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн Улсын бүртгэлийн тухай хуулиудад өөрчлөлт оруулна/ | Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинээр/ | Монгол Улсын Ерөнхийлөгч | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| **3. Улсын Их Хурлын гишүүдээс санаачлах хуулийн төсөл** | | | | | |
| 141 | Төрийн тогтолцоонд эрх мэдэл хуваарилалтын болон хяналт, хариуцлагын эрх зүйн шинэ орчин бий болгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулах | Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | Улсын Их Хурлын гишүүн П.Алтангэрэл, З.Алтай, Г.Батхүү, С.Бямбацогт, Р.Буд, А.Тлейхан, Ц.Цэнгэл | 2010 | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 142 | Улсын Их Хурлын төлөөлөл, хууль тогтоох, хяналтын чиг үүргүүдийг тодорхой болгож Улсын Их Хурлын бүтэц, зохион байгуулалтыг төлөөллийн болон мэргэшсэн парламентын шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, Улсын Их Хурлын гишүүдийн эрх зүйн статусыг боловсронгуй болгох | Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин, Су.Батболд, Б.Батбаяр, Э.Бат-Үүл, Ц.Баярсайхан, Р.Буд, Д.Ганхуяг, Н.Ганбямба, Д.Дондог, Х.Жекей, С.Оюун, Д.Оюунхорол, Ч.Хүрэлбаатар, З.Энхболд, Х.Тэмүүжин | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 143 | Улсын Их Хурлын гишүүний болон Улсын Их Хурлын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, олон нийтийн санаа бодолд үндэслэгдсэн, мэргэжлийн үйл ажиллагаагаар дэмжигдсэн эрх зүйн орчинтой болгох, хууль тогтоох болон хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ олон нийтийн санал, гомдлыг тусгах үүднээс мэргэжлийн Байнгын хороонд иргэдийн санал, гомдлыг хэлэлцэх, зохион байгуулалт, журмыг бий болгох | Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшин, Су.Батболд, Б.Батбаяр, Э.Бат-Үүл, Ц.Баярсайхан, Р.Буд, Д.Ганхуяг, Н.Ганбямба, Д.Дондог, Х.Жекей, С.Оюун, Д.Оюунхорол, Ч.Хүрэлбаатар, З.Энхболд, Х.Тэмүүжин | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 144 | Үндсэн хуулийн цэцийн чиг үүрэг, бүрэн эрхийг Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлж, Цэцийг Үндсэн хуулийн шүүх болох чиглэл рүү нь шинэтгэж, иргэдийн Үндсэн хуульд заагдсан үндсэн эрхээ хамгаалуулах эрх зүйн баталгааг бүрдүүлэх, Цэцийн гишүүдийн ялгамжтай эрх зүйн статусыг нэг болгож Цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох зэрэг эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуулийн болон эрх зүйт ёсны шаардлагад нийцүүлж, Цэцийн гишүүний улс төрийн болон ашиг сонирхлын зөрчлийг хязгаарлах чиглэлээр өөрчлөлт хийх | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 145 | Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах журмыг боловсронгуй болгож Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээг Үндсэн хуулийн үзэл санаатай нийцүүлж өөрчлөх, иргэний Үндсэн хуульд заагдсан үндсэн эрхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх зарчим, журмыг хуульчлан тогтоох | Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 146 | Сонгуулийн төв байгууллагын эрх, үүргийг тодорхой болгож зарим зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг хуулийг боловсронгуй болгох | Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Буд, Д.Лүндээжанцан, Ч.Сайханбилэг, З.Энхболд, Д.Оюунхорол, Д.Арвин, Э.Бат-Үүл, Су.Батболд, С.Ламбаа, Д.Одхүү, Д.Одбаяр, С.Оюун, Ж.Сүхбаатар | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 147 | Улсын Их Хурлын сонгуулийн үйл ажиллагааг төгөлдөржүүлж хууль тогтоомж зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх | Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Буд, Д.Лүндээжанцан, Ч.Сайханбилэг, З.Энхболд, Д.Оюунхорол, Д.Арвин, Э.Бат-Үүл, Су.Батболд, С.Ламбаа, Д.Одхүү, Д.Одбаяр, С.Оюун, Ж.Сүхбаатар | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 148 | Орон нутгийн Хурлын сонгуулийг хуулийн дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх | Орон нутгийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Буд, Д.Лүндээжанцан, Ч.Сайханбилэг, З.Энхболд, Д.Оюунхорол, Д.Арвин, Э.Бат-Үүл, Су.Батболд, С.Ламбаа, Д.Одхүү, Д.Одбаяр, С.Оюун, Ж.Сүхбаатар | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 149 | Санал асуулгыг орон нутгийн хэмжээнд явуулж болох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | Орон нутгийн санал асуулгын тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар | 2010 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 150 | Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Э.Мөнх-Очир, Ж.Сүхбаатар, Ц.Цэнгэл, Ж.Батсуурь | 2009 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 151 | Төсвийн талаархи төрийн байгууллага, албан тушаалтны эрх, үүрэг, төсвийн хяналт, хариуцлагатай холбогдсон харилцаа, орон нутгийн эрх мэдэлтэй холбогдсон асуудлыг боловсронгуй болгох | Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай /шинэчилсэн найруулга/, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай /шинэчилсэн найруулга/ | Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Үүл | 2009 | Төсвийн байнгын хороо |
| 152 | Хот, тосгоны статусыг нарийвчлан хуульчилж эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Дамба-Очир, Ж.Сүхбаатар | 2010 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 153 | Хилийн хяналтын байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, хилийн бүсэд ажил, үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Жекей | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 154 | НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож үүрэг гүйцэтгэж буй цэргийн албан хаагчийн эрсдэлийн даатгалын тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, тэтгэвэрт гарах үед нь офицер, ахлагч нарт орон сууц, газар олгох асуудлыг хуульчлах | Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын ИХ Хурлын гишүүн Х.Жекей, Р.Амаржаргал, Я.Батсуурь, Ц.Шинэбаяр, З.Энхболд | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 155 | Цэргийн багийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах шийдвэр гаргах асуудлаар чиг үүргийн зөрчил, давхардлыг арилгах | Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргал, Я.Батсуурь, Х.Жекей, Ц.Шинэбаяр, З.Энхболд | 2009 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 156 | Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Засгийн газарт зөвлөмж болгосны дагуу тэсэрч дэлбэрэх бодисын эргэлттэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, импорт, худалдааг төвлөрүүлэн зэвсэгт хүчний харьяалалд шилжүүлэхтэй холбогдсон эрх зүйн үндэс бүрдүүлэх | Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргал, Я.Батсуурь, Х.Жекей, Ц.Шинэбаяр, З.Энхболд, Э.Мөнх-Очир | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 157 | Хүн амын нөхөн үржихүйн бодлогыг төрийн бодлогоор дэмжиж олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүдийг урамшуулах | Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Р.Буд | 2009 | Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 158 | Төрийн байгууллагаас хоршоотой харилцах харилцааг тодорхой болгох | Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд | 2011 | Эдийн засгийн байнгын хороо |
| 159 | Хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээлэл нээлттэй байх, мэдээлэл авах хэлбэрүүдийг тусган байгууллага, албан тушаалтан, иргэний эрх, үүргийг тодорхойлох | Мэдээлэл авах эрх чөлөөний тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Су.Батболд, Э.Бат-Үүл, С.Ламбаа, С.Оюун | 2009 | Хууль зүйн байнгын хороо |
| 160 | Байгууллагын нууцын тухай хуулийг хүчингүй болгож, төрийн нууцын хүрээ хязгаарыг тодорхой болгох | Төрийн нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Су.Батболд, Э.Бат-Үүл, С.Ламбаа, С.Оюун | 2009 | Хууль зүйн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороод |
| 161 | Захиргааны үйл ажиллагааны захиргааны суурь зохицуулалтыг хуульчлан, нийтлэг харилцааг нэг ерөнхий хуулиар зохицуулах | Захиргааны үйл ажиллагааны тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Д.Лүндээжанцан, Х.Тэмүүжин | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 162 | "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенци, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол"-д нэгдэн орсонтой холбогдуулан Эрүүгийн хууль болон бусад хуулийн хүн худалдаалахтай холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах | Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Жекей, З.Энхболд | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 163 | Гэр бүлийн хүчирхийлэл, дарамт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Жекей, З.Энхболд | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 164 | Компьютерийн файл, мэдээллийн сүлжээгээр дамжуулж байгаа баримт бичгийг цаасан баримт бичгийн нэгэн адил үзэж цахим гарын үсэг хэрэглэх, түүнийг баримтжуулах | Цахим /электрон/ гарын үсгийн тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Д.Энхбат, Ч.Сайханбилэг, З.Энхболд | 2010 | Хууль зүйн байнгын хороо |
| 165 | Гэр хорооллыг орон сууцжуулах асуудлыг бие даасан хуулиар зохицуулах | Гэр хорооллыг орон сууцжуулах тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Ц.Батбаяр, Д.Ганхуяг, Д.Очирбат | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 166 | Орон нутагт явуулж байгаа сүм, хийдийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, тодорхой стандарт, шаардлагыг тавих | Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог | 2010 | Төрийн байгуулалтын байнгын хороо |
| 167 | Улсын чанартай болон орон нутгийн зам ашиглалтын хураамж, давхар татварын асуудлыг хуульчлах | Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Д.Дондог | 2010 | Төсвийн байнгын хороо |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 168 | Говийн болон алслагдсан бүс нутгийн хүн амд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн орчныг бий болгож бүсийн нэмэгдэл олгох, бүсийн нэмэгдлийг 25 хувиар тогтоох асуудлыг хуульчлах | Говийн болон алслагдсан бүс нутгийн бүсийн нэмэгдэл олгох тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн П.Алтангэрэл, А.Тлейхан, Д.Оюунхорол, Г.Занданшатар, Ц.Баярсайхан, С.Бямбацогт, Х.Бадамсүрэн, Ж.Батсуурь, Р.Буд, Р.Раш, Ц.Цэнгэл, Ц.Дашдорж | 2010 | Төсвийн болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо |
| 169 | Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ногдуулж байгаа татварын хэмжээг Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа дотоодын аж ахуйн нэгжийнхтэй ижил тэнцүү татвар ногдуулдаг байх зохицуулалтыг тусгах | Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн П.Алтангэрэл, З.Алтай, Г.Батхүү, Р.Буд, Ц.Цэнгэл | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 170 | Ашигт малтмалын тухай хуулийг боловсронгуй болгох | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн П.Алтангэрэл, Г.Батхүү, Ц.Цэнгэл | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 171 | Уул уурхайн үйлдвэрлэл, газрын хэвлийн ашиглалтыг зохицуулах бие даасан хуулийг гаргаж уул уурхайн салбарыг хөгжүүлэх | Уул уурхайн тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Х.Бадамсүрэн, С.Бямбацогт, А.Тлейхан | 2010 | Эдийн засгийн байнгын хороо |
| 172 | Малчдын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнийг зах зээлийн үнэд ойртуулах, малчдын орлогыг тогтворжуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор мал аж ахуйн бүтээгдэхүүний төвлөрсөн агент болох биржийг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх | Хөдөө аж ахуйн биржийн тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн З.Алтай, Р.Буд, Ц.Цэнгэл | 2010 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 173 | Алслагдсан бүс нутагт үйлдвэрлэл эрхэлж, иргэдийг ажлын байраар хангаж бизнес эрхэлж байгаа жижиг, дунд үйлдвэрлэлийн салбаруудыг бүртгэлийн, орлогын албан татвараас нь хөнгөлөх, чөлөөлөх, онцгой хөнгөлөлтийг эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Улсын Их Хурлын гишүүн Я.Батсуурь, Г.Батхүү, Д. Кёкүшюзан Батбаяр, Ш.Сайхансамбуу | 2009 | Төсвийн байнгын хороо |
| 174 | Улсын Их Хурлаас тогтоосон стратегийн ач холбогдол бүхий 15 ордын нийт нөөцөд түшиглэн "Баян Монгол" корпорацийг байгуулан хувьцааг нь Монгол Улсын иргэн бүрт тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх | Баянмонгол корпораци байгуулах тухай /шинээр/ | Улсын Их Хурлын гишүүн Л.Болд | 2009 | Төсвийн байнгын хороо |
| | **Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл** | | | | |
| 1 | Олон улсын жишигт нийцсэн хотууд шинээр бий болгож, үйлдвэрлэл, үйлчилгээг даган үйлдвэр- хотуудын инженерийн дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоо сайжирч, ажил эрхлэлт нэмэгдэн, хүн амын амьжиргааны түвшин дээшилж, бүс нутагт тогтвортой ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэх | Хөшигтийн хөндийд баригдах шинэ нисэх онгоцны буудлыг даган бий болох хот, Тавантолгой, Оюутолгой зэрэг стратегийн томоохон орд газруудыг түшиглэсэн орчин үеийн шийдэл бүхий 10-20 мянган хүн амтай хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороод |
| 2 | Хүн амын нутагшилт хөгжлийн хүрээнд монгол орны байгаль, цаг уурын нөхцөл, эрдэс баялагийн нөөц, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, хүрээлэн буй байгаль орчны хамгаалал, тухайн төв, суурингийн суурьшлын өвөрмөц онцлог, цаашдын хөгжлийн төлөвийг тодорхойлох | Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл батлах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороод |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төслийн хүрээнд бүсчилсэн хөгжлийн стратеги зорилтыг хэрэгжүүлэх, бүлэг суурингийн зөв тогтолцоог тогтоох, бүлэг суурингийн төвүүдийг тодорхойлох | Бүлэг суурингийн тогтолцоо батлах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороод |
| 4 | Нийслэл хотод төвлөрч буй хүн ам, үйлдвэрлэлийн бөөгнөрлийг задалж, улмаар хот орчим болон хөдөөгийн хөгжлийн ялгааг арилгах, бүс нутаг, аймгуудын хөгжлийн тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгах, дэд бүтцийн сүлжээнд холбогдох боломжтой, хөгжлийн чиг хандлагаараа бусдаас давуу талтай, түүхий эдийн нөөцдөө тулгуурласан томоохон суурин газрын үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийн цаашдын хандлагыг цогц байдлаар хөгжүүлэх арга хэмжээ авах | Үйлдвэр-хотуудын талаар авах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороод |
| 5 | "Цагааннуур" худалдааны чөлөөт бүс нь төлөвлөлтийн дагуу хөгжих, тухайн бүс нутагт амьдарч буй иргэд ажлын байраар хангагдаж орон нутагтаа тогтвортой ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалт, экспортыг нэмэгдүүлэх | Цагааннуурын худалдааны чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай | Засгийн газар /ЗТБХБЯ/ | 2011 | Төрийн байгуулалтын болон Эдийн засгийн байнгын хороод |
| 6 | Малчдын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж малчид хэвийн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх | Малчдын талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай | Засгийн газар /ХХААХҮЯ, ХЗДХЯ/ | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |
| 7 | Монгол Улсын хөгжлийн түлхүүр болох авто замыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх | Авто замын хөгжлийн мастер төлөвлөгөө батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Раш, Г.Батхүү, Ц.Цэнгэл | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 8 | Нүүрсний талаар төрөөс баримтлах бодлого, зохицуулалт хангалтгүйгээс нүүрс үнэгүйжих хандлагаас сэргийлэх, нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулах | Нүүрс хөтөлбөр батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Х.Бадамсүрэн, А.Тлейхан | 2009 | Эдийн засгийн байнгын хороо |
| 9 | Аюулгүй байдлын шинэ орчин, нөхцөлд дайн, зэвсэгт мөргөлдөөний тухай асуудлуудыг өөрөөр авч үзэх болсонтой холбогдуулан, түүнчлэн терроризм, хууль бус цагаачид /дүрвэгсэд/ болон бусад аюул заналын цар хүрээ нэмэгдсэн зэргээс шалтгаалан тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөн тэмцэх асуудлуудыг шинээр томъёолж цэргийн номлолыг шинэчлэх, төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогын баримт бичиг батлагдсантай холбогдуулан "Орон нутгийн хамгаалалт"-ын тухай асуудлыг улс орноо батлан хамгаалахад хүн ам, эдийн засаг, нутаг дэвсгэрээ бэлтгэх чиглэлээр цэргийн номлолд тусгах, зэвсэгт хүчний тайван цагийн олон талт үүргүүдийг тодотгох | Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс батлах тухай | Улсын Их Хурлын гишүүн Р.Амаржаргал, Я.Батсуурь, Х.Жекей, Ц.Шинэбаяр, З.Энхболд | 2010 | Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо |
| 10 | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн хэрэглээг нэмэгдүүлэх, дотоодын болон гадаадын зах зээлд гаргах, түүхий эдийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх | Дотоодын үйлдвэрүүдийн хэрэгцээнээс 2009 онд илүү гарсан малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос, ноолууран бүтээгдэхүүнийг хилийн боомтуудаар гаргах замаар иргэдийг мөнгөжүүлэх тухай | Улсын Их Хурлын гишүүн Г.Батхүү, Р.Бүд, Ц.Цэнгэл | 2009 | Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 04-ний өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот

### Төрөөс малчдын талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрөөс малчдын талаар баримтлах бодлого"-ыг хавсралтаар баталсугай.

2. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай:

1/ төрөөс малчдын талаар баримтлах бодлогын эхний үе шат /2009-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2009 оны 2 дугаар улиралд багтаан батлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

2/ төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилт, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /Б.Батбаяр/-нд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 39 дүгээр тогтоолын хавсралт

### Төрөөс малчдын талаар баримтлах бодлого

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого нь малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, хүч, хөдөлмөрөө хоршихыг урамшуулах, бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгох, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг дэмжих замаар малчдын тав тухтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх, мал аж ахуйг эрсдэл багатай, баталгаатай хөгжүүлэхэд чиглэнэ. Энэ нь малчин, малчин өрхийг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулалтын сүлжээг орон нутагт бий болгон хөгжүүлэхэд төр, хуулийн этгээд, төрийн бус байгууллага, малчдын хамтын хүчин чармайлтыг бий болгон хөгжүүлэх замаар хэрэгжинэ.

1.2. Хөдөөгийн хөгжлийн талаархи олон улсын туршлага нь нутгийн иргэдийн үүсгэл санаачилга, тэдний үйл ажиллагаа, санхүүжилтийг тал бүрээр дэмжиж, дэлхийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, үйл ажиллагаатай аль болох уялдуулан түүний бүрэлдэхүүн хэсэг болгож чадсан нөхцөлд амжилтанд хүрдгийг нотолж байна. Энэ талаар 1992 онд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байгаль орчин, хөгжлийн чуулган, 2000-2001 онд болсон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Мянганы хөгжлийн чуулганаар баталсан олон улсын санамж бичиг, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Цөлжилттэй тэмцэх Конвенци, Дэлхийн хүнсний чуулган, Ядуурлыг бууруулах стратеги зэрэг баримт бичгүүдэд тусгалаа олсон байна.

1.3. Энэхүү бодлогыг боловсруулах эрх зүйн үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги, Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого зэрэг баримт бичиг болно. Төрөөс хэрэгжүүлж байгаа дээрх бодлогын баримт бичгүүдэд мал аж ахуйн салбарын хөгжил, үйлдвэрлэлийн эрчимжилтийн талаар тодорхой тусгагдсан байдаг боловч үйлдвэрлэлийн бүтээгч гол хүчин болох малчдын талаар баримтлах бодлогын чиглэл тодорхойгүй байна. Улсын Их Хурлын 2008 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 35 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2008-2012 он/"-т малчид, малчин өрхийн талаар тодорхой зорилтууд тусгагдсан. Мал аж ахуй эрхлэн хүн амыг мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр, хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр хангаж, байгаль, цаг уурын эрсдэл ихтэй хүнд нөхцөлд ажилладаг малчдын амьдрал, малчин өрхийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн бодлого, стратегийг дэс дараатай хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

#### Хоёр. Бодлогын зорилго, баримтлах зарчим, чиглэл

2.1.Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын зорилго нь малчин хүнийг өөрийг нь хөгжүүлэх замаар малчин өрхийн ашиг, орлогыг

нэмэгдүүлэн амьдралын түвшинг дээшлүүлэхэд оршино.

2.2. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

2.2.1. хүний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, шударга ёс, тэгш байдал, хууль дээдлэх;

2.2.2. төрөөс малчин өрхийн эдийн засгийн чадавхи, бололцоо, хүсэл сонирхолд нь нийцсэн дэмжлэг үзүүлэх;

2.2.3. хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, тэргүүний арга, туршлага, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, эзэмшүүлэх, нутагшуулах;

2.2.4. малчин хүний ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах, туслан хөгжүүлэх үйл ажиллагааг аль болох анхан шатны нэгжид, баг, хорооны түвшинд хөхиүлэн дэмжих;

2.2.5. бэлчээрийн мал аж ахуйн уламжлалт болон дэвшилтэт арга барил, түүх, соёлоо нандигнан хадгалж, өвлөн хөгжүүлэх.

2.3. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого нь дараахь чиглэлтэй байна:

2.3.1. малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх;

2.3.2. малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох;

2.3.3. малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах.

**Гурав. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын чиглэлийг хэрэгжүүлэх стратегийн зорилт**

3.1. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, ядуурлаас ангид байлгах, тэдэнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгоход чиглэсэн эрх зүй, эдийн засаг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.1.1. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчны бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхөд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд хүрэлцэх хэмжээний газрыг эзэмшүүлэх, отрын бүс нутаг байгуулах, сумдад бэлчээр ашиглалтын хороог ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.2. хувь хүний орлогын албан татвараас малчин өрхийг чөлөөлж, бэлчээр ашигласны төлбөрийг эдийн засаг, экологийн үнэлгээнд үндэслэн ялгавартай тогтоох, уг төлбөрийн 30-аас доошгүй хувиар сумын бэлчээр хамгаалах, сэргээх болон мал аж ахуйн эрсдлийн сан байгуулж, зарцуулж байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

3.1.3. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч болон малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, малчин өрхийг мал, амьтан, эд хөрөнгийн даатгал, санхүү, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд хамруулах, хөрөнгийн гэрчилгээ, харилцах данс, бүртгэлтэй болгож банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, лизингийн үйлчилгээнд хамрагдах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.4. малчин өрх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл нь бизнесийн өөр төрлийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.5. мал аж ахуйн үйлдвэрлэлийн онцлогт нийцсэн хөдөлмөрийн харилцааны хэв шинжийг судалж, туслах малчны хөдөлмөрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулан орлого багатай малчдыг өөр салбарт шилжин ажиллах, бизнес эрхлэхийг дэмжих тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

3.1.6. малчдын хөдөлмөр, нийгмийн хамгааллын эрх зүйн орчныг бүрдүүлж малчдыг нийгмийн даатгалд заавал хамруулах тогтолцоонд шилжүүлэх, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх;

3.1.7. мал аж ахуйн салбарт хүүхэд хөдөлмөр эрхлэх нөхцөл, шалгуурыг тодорхой болгож, тус салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг арилгах бодлого хэрэгжүүлэх;

3.1.8. малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого, бүтээгдэхүүний чанарыг урамшуулах эрх зүй, эдийн засаг, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3.1.9. малчдын бүлэг, хоршоо, нөхөр-лөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлэх;

3.1.10. бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа малчин өрхийг малын чанараа сайжруулах болон өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийг арвин ашиг шимт нэг төрлийн мал дагнан төрөлжүүлэн зах зээлийн мэдээлэл, бизнес төлөвлөгөө бүхий аж ахуйн хэв шинжийг олоход нь дэмжлэг үзүүлэх;

3.1.11. бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа өрхийг эдийн засгийн ашиг сонирхол дээр тулгуурласан малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр хамтын аж ахуй эрхлэх эрх зүй, санхүү, эдийн засгийн нөхцөлийг бий болгон хөгжүүлэх;

3.1.12. богд шилжүүлснээр бэлчээрийн 100 хүртэл малтай, зөвхөн түүнээс өрхийн орлого нь бүрдэж байгаа малчин өрхийн хөдөл-

мөрийн чадвартай гишүүдийг эдийн засгийн бусад салбарт шилжүүлэх, эсхүл малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлд хамруулан ажлаар хангах бодлого хэрэгжүүлэх.

3.2. Малчин өрхийн эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зохион байгуулалтыг сайжруулж бүтээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн оновчтой тогтолцоо бий болгох бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.2.1. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд бизнес, санхүү, зээл, хууль зүйн туслалцаа үзүүлэх, мал эмнэлэг, үржлийн болон хөдөө аж ахуйн шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх үйлчилгээг орон нутагт хөгжүүлж, чанарыг сайжруулах;

3.2.2. малчдын өөрсдийнх нь санал болгосон хүнийг тусгайлан сургах замаар малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн удирдлагыг бэлтгэх арга хэмжээг төрөөс санаачлан хэрэгжүүлэх, орон нутгийн удирдлага, багийн Засаг дарга нарт энэ чиглэлээр сургалт зохион байгуулах;

3.2.3. малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, гарал үүслийг тодорхой болгон нэмүү өртөг бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бий болгох замаар малчдын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Мах үйлдвэрлэл", "Сүү үйлдвэрлэл", "Арьс, шир бэлтгэл", "Ноос, ноолуур бэлтгэл" зэрэг хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;

3.2.4. бүтээгдэхүүнийг боловсруулах, борлуулах зах зээлийн тогтолцоог бүс нутгийн онцлогт нийцүүлэн бий болгож хөгжүүлэх;

3.2.5. малын гаралтай түүхий эд (арьс, шир, ноос, ноолуур, өлөн гэдэс, эвэр, туурай, яс, хялгас зэрэг)-ийг худалдан авах, түүнд чанарын анхан шатны ангилалт, боловсруулалт хийх цех, нэгжийг малчдын оролцоо бүхий малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр сум бүрт бий болгох, бүсүүдэд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх;

3.2.6. малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэл, чанарын стандарт, түүнийг хэрэглэх заавар, журмыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;

3.2.7. бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгөөр усны хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг гаргах, засварлахын зэрэгцээ малчдын үүсгэл, санаачилгаар худаг гаргах, засварлах, цас, борооны ус тогтоох, усан сан, нуур, цөөрөм байгуулахыг төрөөс урамшуулан дэмжих;

3.2.8. малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор худаг ус гаргах, тэжээл бэлтгэх зэрэг мал аж ахуйн үйлдвэрлэлд шаардлагатай олон нийтийг хамарсан арга хэмжээг түлхүү зохион байгуулах;

3.2.9. шилжин суурьшсан малчин байсан иргэдийг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан нийгмийн үйлчилгээнд хамруулах, ажлын байраар хангах бодлого хэрэгжүүлэх;

3.2.10. "Малчдын орон сууц", "Монгол гэр" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

3.2.11. малчин өрх бүрийг 2015 он гэхэд 100 хувь радиотой болгох, цахилгааны эх үүсвэртэй болгох хөтөлбөрийг үргэлжлүүлэх, малчдад цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ болон зах зээлийн мэдээллийг гар утсаар хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.2.12. малчдыг байгалийн гамшгийн үед өмсөхөд зориулсан дулаан, тохиромжтой хувцсаар хангах, энэ чиглэлээр дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

3.2.13. бүс нутаг, аймгийн түвшинд хөдөө аж ахуйн машин, техник нийлүүлэх, лизинг, засвар үйлчилгээ, сэлбэгээр хангах тогтолцоо бий болгох, техник ашиглалтын сургалт, үзүүлэх сургууль зохион байгуулж байх;

3.2.14. өвс, тэжээлийн чанар, сав, баглаа боодлын стандартыг шинэчлэн тогтоож шинэ технологи нэвтрүүлэн овор багатай, чанар сайтай тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;

3.2.15. тэжээлийн нөөцийн хэмжээ, хүртээмж, байршлыг оновчтой тогтоох, түүний хадгалалт, хамгаалалт, зарцуулалтын менежментийг сайжруулах, сум, багийн түвшинд өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээ бий болгох;

3.2.16. уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тэжээлийн ургамлын улсын үрийн нөөцтэй болж нутагшсан сортын үрийг баталгаажуулж, түүнийг тариалах ажлыг өргөжүүлэх, ургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамлын тариаланг нэмэгдүүлэх;

3.2.17. малын хашаа, дулаан байрны зураг төсөл гаргаж материалын нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх;

3.2.18. мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрийг хөнгөвчилж хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;

3.2.19. аймаг, сумын түвшинд арвин ашиг шимтэй мал, амьтан бойжуулж, борлуулах үржлийн аж ахуйг бий болгон хөгжүүлэх, тухайн орон нутгийн малын чанарыг сайжруулах арга хэмжээг дэмжих;

3.2.20. малд зайлшгүй үзүүлэх мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэр төрлийг шинэчлэн тогтоож, хэрэгжүүлэх нэгжийг сум бүрт ажиллуулах;

3.2.21. мал, амьтны шүлхий, мялзан өвчнөөс тайван орны жагсаалтад орж, тодорхой бүс нутгийг малын гоц халдварт болон нэн аюултай зооноз өвчнөөс эрүүлжүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын чөлөөт байдлыг хангах, экологийн цэвэр үндэсний нэрийн бүтээгдэхүүн бий болгож гадаад зах зээлд өрсөлдөх бодлогыг алхам алхамаар хэрэгжүүлэх.

3.3. Малчдын өөрөө өөртөө туслах, өөрөө өөрийгөө удирдах иргэний нийгмийн бүтцийг бий болгон хөгжүүлэхийг дэмжих, боловсрол, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тусгай мэргэжил эзэмшүүлэх, малчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах замаар амьдралын дадал, заншилд өөрчлөлт оруулах бодлогын чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилт дэвшүүлэн хэрэгжүүлнэ:

3.3.1. малчны өөрөө өөрийгөө удирдах анхан, дунд, дээд шатны байгууллага бий болгох, анхан шатны байгууллагыг удирдлага, менежмент, зохион байгуулалтын нэгдсэн хэлбэрт оруулах бүтэц бий болох боломж, нөхцөлийг бүрдүүлэх, малчдын дунд сургалт явуулж оролцооны аргаар албан ёсны зохион байгуулалтын бүтцэд шилжих үйл явцыг төрөөс дэмжин хөгжүүлэх;

3.3.2. эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид болон малчид сайн дураар нэгдэн төрийн бус байгууллага, холбооны зохион байгуулалтад орох боломж, нөхцөлийг бүрдүүлэх;

3.3.3. малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл, холбоог бэхжүүлэх зорилгоор тэдгээрийг гадаад улс, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж буй дунд, урт хугацааны төсөл, хөтөлбөрт хамруулах;

3.3.4. малчид, малчин өрх, мал аж ахуйн үйлдвэрлэл, зах зээлийн талаархи мэдээллийн цогц сан бий болгон ажиллуулж малчдыг мэдээллээр хангах;

3.3.5. хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар тусгайлсан төсөл, хөтөлбөрийг бүс нутгийн онцлог байдлыг харгалзан боловсруулж хэрэгжүүлэх;

3.3.6. малчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол, бүрэн хамруулж, зардлыг төрөөс хариуцах арга хэмжээг хэрэгжүүлэх, сум, багийн эмнэлгийг боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны болон зайны сургалтад хамруулах;

3.3.7. мал аж ахуйн үйлдвэрлэлийн сөрөг нөлөөллийг судалж, мал, амьтнаас хүнд дамжин халдварлах өвчнөөс малчид, хүн амыг хамгаалах болон осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, ахуйн болон ундны цэвэр усаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.3.8. малчин өрхийн эдийн засаг, бизнес, ур чадварын түвшинд нийцсэн сургалтын ялгавартай хөтөлбөр бий болгож хөгжүүлэх, сургагч багш нарыг сум бүрт бэлтгэж мэргэшүүлэх;

3.3.9. малчдад зориулсан сургалтыг орон нутагт үйлдвэрлэлийн явцад хэрэгжүүлэх байгууллага, малчны байнгын болон түр сургуулийг бий болгон бэхжүүлэх, түүгээр дамжуулан шат дараалсан сургалт (анхан шатны танин мэдэхүйн сургалтаас эхлээд технологи дамжуулах, нутагшуулах, инноваци нэвтрүүлэх зэрэг)-ыг зохион байгуулах;

3.3.10. залуу болон ирээдүйн малчдыг мэргэжлийн, түр болон албан бус сургалтаар хэтийн төлөвлөгөөтэй бэлтгэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, малчдад зориулсан зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.3.11. малчдад зориулсан сонин, сэтгүүл тогтмол гаргахыг дэмжих, мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, тусгай хөтөлбөрийг боловсруулж хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

3.3.12. орлого багатай малчдыг бусад төрлийн аж ахуй эрхлэх, бие даан бизнес эрхлэх ур чадварыг дээшлүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх, тэдний хэрэгцээ, чадавхи, санаачилгыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг үндэсний болон олон улсын төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжүүлэх;

3.3.13. малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах оновчтой арга механизмыг бий болгох, ерөнхий боловсрол эзэмших болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцахад нь дотуур байраар хангахад төрөөс дэмжлэг үзүүлэх.

**Дөрөв. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр**

4.1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд улсын төсвийн 1.0-ээс доошгүй хувийг зарцуулна.

4.2. Малчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, эрхэлж буй аж ахуй, нийгмийн баталгааг сайжруулах зэрэг арга хэмжээг санхүүжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийг нэн тэргүүнд зориулна.

4.3. Малчдад чиглэсэн үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, иргэдийн хөрөнгө болон малчдын өөрсдийн оролцоог нэмэгдүүлж тэдний хөрөнгө оруулалт, санхүүжилтийг хөхиүлэн дэмжинэ.

**Тав. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга зам**

5.1. Малчдын амьдралын түвшинг дээшлүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

5.2. Малчдын амьдралыг сайжруулах, малчдын аж ахуйг хөгжүүлэхэд төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

5.3. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг үе шат бүрээр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлуулан гүйцэтгэнэ.

***Зургаа. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үе шат, шалгуур үзүүлэлт***

6.1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шат /2009-2015 он/-нд дараахь үр дүнд хүрнэ:

6.1.1. малчдын ахуй амьдрал, аж ахуйг сайжруулахтай холбогдсон эрх зүй, эдийн засаг, нийгмийн таатай орчин бүрдэнэ;

6.1.2. малчин өрх, малчдын бүлэг, фермер, хоршоо, нөхөрлөлийн хэв шинжит аж ахуй гэсэн бизнесийн тогтвортой, үр ашигтай, өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжтой болно;

6.1.3. малчдын өөрөө өөрийгөө удирдах болон өөрөө өөртөө туслах байгууллагын үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болж, малчдын мэдлэг, зохион байгуулалт сайжирч, гадаад улсын болон олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаат үр ашигтай хүлээн авах нөхцөл бүрдэнэ;

6.1.4. мал аж ахуйг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сум, багийн түвшинд бий болгож, малын өвс, тэжээл худалдаалах байнгын цэг, нэгдсэн сүлжээтэй болсон байна;

6.1.5. мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний бөөний болон биржийн худалдаа явуулах тогтолцоог бий болгож, малчдын орлого нэмэгдэнэ;

6.1.6. малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах жижиг, дунд үйлдвэр орон нутагт байгуулан ажиллуулж, орон нутагт ажлын байр нэмэгдэн малчдын дунд далд ажилгүйдэл арилах нөхцөл бүрдэнэ;

6.1.7. эхний үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 50 хувиар өснө;

6.1.8. эхний үе шатанд эрүүл мэндийн даатгалд малчдын 70-аас доошгүй хувийг, нийгмийн даатгалд малчдын 50-аас доошгүй хувийг хамруулсан байна.

6.2.Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хоёрдахь үе шат /2016-2020 он/-нд дараахь үр дүнд хүрнэ:

6.2.1. малчид эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд 100 хувь хамрагдаж, төрөөс үзүүлэх нийгмийн халамж, үйлчилгээг хүртэх болно;

6.2.2. малчид аж ахуй эрхлэх, хөдөлмөр, хүчээ хорших мэдлэг, дадлагаа нэмэгдүүлж, тэдний амьдралын нөхцөлд өөрчлөлт гарна;

6.2.3. хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлснээр малчдын орлогын түвшин 80 хувиар өснө.

***Долоо. Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын чиглэлүүдийг хэрэгжүүлэх хуваарь***

7.1. Бодлогын 1 дэх чиглэлийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, санхүүгийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

7.2. Бодлогын 2 дахь чиглэлийг хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, зам, тээвэр, барилга, хот байгуулалтын, эрдэс баялаг, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, онцгой байдал болон мал эмнэлэг, үржлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

7.3. Бодлогын 3 дахь чиглэлийг боловсрол, соёл, шинжлэх ухааны, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн, эрүүл мэндийн болон хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын Тамгын газар хамтран хэрэгжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2009 оны 05 дугаар сарын 25-ны өдөр** **Дугаар 119** **Улаанбаатар хот**

**Архангай аймгийн харъяат зарим эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнах тухай**

Олон хүүхэд төрүүлж, өсгөн хүмүүжүүлсэн Архангай аймгийн харъяат дор дурдсан эхчүүдийг "Алдарт эх" одонгоор шагнасугай.

**"АЛДАРТ ЭХ" НЭГДҮГЭЭР ОДОНГООР:**

**Булган сум**

1. Самдангийн Отгонбат - Тусгалт багийн малчин

**Их тамир сум**

2. Самбуугийн Сувдаа - Хан-Өндөр багийн малчин
3. Дамдинбазарын Цэрэндэжид - Борт багийн малчин

**Өгийнуур сум**

4. Саранчимэгийн Бямбасүрэн - Дойт багийн малчин

**Өндөр-Улаан сум**

5. Цэрэннадмидын Дамцагдулам - Бэлхи багийн малчин
6. Намхайн Бужинлхам - Баянгол багийн малчин

**Тариат сум**

7. Чүлтэмийн Тэрбиш - Хорго багийн малчин

**Хайрхан сум**

8. Хараагийн Наранцэцэг - Могой багийн малчин

**Цахир сум**

9. Жамбаагийн Банзай - Хан-Уул багийн малчин

**Цэнхэр сум**

10. Дэндэвийн Пүрэвжав - Буйлан багийн малчин

11. Гүрсэдийн Сарангэрэл - Цэцэрлэг багийн малчин

**Хотонт сум**

12. Уртнасангийн Оюунбилэг - Хөвөөр багийн малчин

13. Даваасүрэнгийн Сайнбуян - Бургалтай багийн малчин

**"АЛДАРТ ЭХ" ХОЁРДУГААР ОДОНГООР:**

**Батцэнгэл сум**

1. Сосорбурамын Доржханд - Хөнөг багийн малчин

**Булган сум**

2. Халтарын Наранцэцэг - Зуунмод багийн малчин

**Ихтамир сум**

3. Норовын Батцагаан - Хөн-Өндөр багийн малчин

**Өгийнуур сум**

4. Пүрвээгийн Буянжаргал - Гэрийн ажилтай

**Өлзийт сум**

5. Баттөмөрийн Азжаргал - Ямаат багийн малчин

6. Цэрэнбямбын Сайханжаргал - Бодонт багийн малчин

7. Одвогмэдийн Сарангэрэл - Бодонт багийн малчин

**Өндөр-Улаан сум**

8. Хүрэлбаатарын Наранцэцэг - Бэлхи багийн малчин

9. Найдангийн Туяа - Ханүй багийн малчин

**Тариат сум**

10. Тойвгоогийн Алтантуяа - Тэрх багийн малчин

11. Санжийн Даваажав - Тэрх багийн малчин

12. Жүгдэрийн Должийхүү - Цагааннуур багийн малчин

13. Махранзын Наранцэцэг - Тэрх багийн малчин

14. Бямбаагийн Энхтуяа - Тэрх багийн малчин

**Төвшрүүлэх сум**

15. Гомбожавын Түмэнцогт - Гэрийн ажилтай

16. Должинжавын Туяа - Цэцэрлэгийн багш

17. Дашзэвэгийн Хишигжаргал - Сумын ЗДТГ-т бичиг хэргийн эрхлэгч

**Хайрхан сум**

18. Нямдаваагийн Эрдэнэчимэг - Могой багийн малчин

19. Навганы Эрдэнэчимэг - ШТС-д түгээгч

20. Авирзидаагийн Одончимэг - Асгат багийн малчин

**Хангай сум**

21. Гомбосүрэнгийн Буяндэлгэр - Гэрийн ажилтай

22. Гэндэнсүрэнгийн Гэрэлсайхан - Гэрийн ажилтай

**Хашаат сум**

23. Авирмэдийн Ариунзолбоо - Цайдам багийн малчин

24. Чадраабалын Үржинбадам - Номгон багийн малчин

**Хотонт сум**

25. Санжийн Лхагвасүрэн - Орхон багийн малчин

26. Гонгорын Түмэнжаргал - Орхон багийн малчин

27. Даансүрэнгийн Цэрмаа - Өндөрсант багийн малчин

28. Дамбийнямын Цэрэнханд - Бургалтай багийн малчин

**Цахир сум**

29. Очирбатын Энхтуяа - Баянгол багийн малчин

**Цэнхэр сум**

30. Гомбын Амарсанаа - Алтан-Овоо багийн малчин

31. Бадамдоржийн Баярмагнай - Алтан-Овоо багийн малчин

32.Жамъянжавын Нарантуяа -Цэцэрлэг багт малчин

33.Тогоохүүгийн Уламсайхан - Цэнхэр багийн малчин

**Цэцэрлэг сум**

34. Бумсангийн Ижилцэцэг - Хужирт багийн малчин

35. Мандаагийн Отгончимэг - Чулуут багийн малчин

36. Дамчаагийн Төмөр - Хужирт багийн малчин

**Чулуут сум**

37. Равдандоржийн Долгорсүрэн - Зуунмод багийн малчин

38. Чимэддагвын Нарантуяа - Халуун ус багийн малчин

39. Мягмарын Сугардулам - Хайрхан багийн малчин

40. Бямбасүрэнгийн Пагамсүрэн - Халуун ус багийн малчин

**Эрдэнэбулган сум**

41. Уртнасангийн Алтанцэцэг - Гэрийн ажилтай

42. Лхамжавын Баасанхүү - Гэрийн ажилтай

43. Дашийн Баясгалан - Хувиараа хөдөлмөр эрхлэгч

44. Самбуугийн Должин - Гэрийн ажилтай

45. Бямбажавын Ичинхорлоо - Гэрийн ажилтай

46. Лхамжавын Нарантуяа - Гэрийн ажилтай

47. Очирбатын Ням - Гэрийн ажилтай

48. Лхамсүрэнгийн Наранхүү - Гэрийн ажилтай

49. Цэрэндоржийн Одгэрэл - Гэрийн ажилтай

50. Сэдбазарын Өлзийсайхан - 5-р багийн малчин

51. Шагдарын Хоролдулам - БК-ын жижүүр

52. Минарын Самбуупилмаа - Гэрийн ажилтай

**Эрдэнэмандал сум**

53. Даваадоржийн Амаржаргал - Идэр-Улаан багийн малчин

54. Лхагвадоржийн Баясгалан - Алаг-Уул багийн малчин

55. Жавзмаагийн Мэндсайхан - Тээл багийн малчин

56. Гүрсэдийн Чимэг - Хан-Өндөр багийн малчин

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2009 оны 05 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 14.00 цаг

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүдэд П.Очирбат, Н.Жанцан, Ж.Болдбаатар, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа, Д.Мөнхгэрэл /илтгэгч/, Б.Пүрэвням нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Очирбал, Улсын Их Хурлын даргын 2009 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 81 дүгээр захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанаар Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийн зарим хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэн 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 29 дүгээр тогтоолоо ирүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэв.

***Нэг. Нийслэлийн Баянгол дүүргийн 13 дугаар хорооны оршин суугч, иргэн Р.Очирбал Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

"... Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно"; мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" хэмээн заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даах шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна"; мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэсэн Үндсэн хуулийн заалтыг шууд зөрчсөн гэж үзэж байна..." гээд өөрийн шаардлагын үндэслэлийг доорхи байдлаар тайлбарласан байна:

"... Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даах шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна"; мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." хэмээн тус тус заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллага нь хуулиар олгосон тусгайлсан чиг үүрэг, эрх хэмжээтэй хийгээд тухайн бүрэн эрхээ хэрэгжүүлэх бодит эрхийн чадамжийг хангахын тулд дээд шатны байгууллага тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг шийдвэрлэхгүй байх зарчмыг бэхжүүлсэн явдал юм. Гэвч Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно"; мөн зүйлийн 25.5-д "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" хэмээн заасан нь Үндсэн хуулийн дээрх заалтуудыг шууд зөрчсөн гэж үзэж байна. Учир нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх хийгээд, энэхүү эрх нь тухайн байгууллагаас өөрийн бүрэн

эрхийн хүрээнд хамаарах асуудлыг шийдвэрлээд батлан гаргасан аливаа шийдвэр, тогтоолыг бусад байгууллага, албан тушаалтан шууд хүчингүй болгох боломжоос хамгаалагдсан байх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран гуравдугаар зүйлд Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байна хэмээн заасан боловч уг зүйлд орон нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг дээд шатны хурал, эсхүл Улсын Их Хурал хүчингүй болгоно гэсэн агуулга байхгүй, байх ч боломжгүй. Хэрэв тухайн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй гэж үзвэл дээд шатны Хурал эсхүл хууль тогтоох байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгох бус шүүхийн байгууллагаас хүчингүй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь Хурал өөрийн эрх хэмжээний асуудлыг шийдвэрлээд гаргасан шийдвэрийг дээд шатны Хурал, эсхүл Улсын Их Хурал хүчингүй болговол энэ нь өөрөө удирдах байгууллагын хэвтээ түвшний харилцааны зарчмыг зөрчин өөрөө удирдах ёсны тогтолцоонд харшилна гэж үзэж байна. ...” гэжээ.

***Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв тухайн нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно” хэмээн нутгийн өөрөө удирдах байгууллагын хуулиар олгосон тусгайлсан чиг үүрэг хийгээд эрх хэмжээг бэхжүүлж өгсөн.

Түүнчлэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Хурал, тэргүүлэгчид, Хурлын дарга, тэдгээрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг нарийвчлан зааж өгсөний зэрэгцээ эрх үүргээ хэрэгжүүлэхдээ гаргасан шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газрын шийдвэрт харшлахгүй байх учиртайг мөн адил хуульчилсан.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5-д “Хурлаас гаргасан тогтоол бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсхүл дээд шатны Хурал хүчингүй болгоно”, “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэж заасан нь нутгийн өөрөө удирдах байгууллагыг Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргахаас хамгаалсан зохицуулалт болсон.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д заасан “...дээд шатны хурал хүчингүй болгоно” гэсэн нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 3 дугаар бүлэгт нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээнд хамаарах асуудлыг шийдвэрлэж буй хэрэг бус харин нэгэнт гаргасан шийдвэрийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэх хөшүүрэг юм. ...” гэсэн байна.

***Гурав. Үндсэн хуулийн цэц энэхүү маргааныг 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Дунд суудлын хуралдаанаар хянан шийдвэрлэж 02 дугаар дүгнэлт гаргасан байна. Үүнд:***

***Дүгнэлтийн үндэслэх хэсгийн 2 дахь заалтад:*** “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “Хурлаас гарсан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн, эсвэл дээд шатны Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно”; мөн зүйлийн 25.5 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй” гэсэн заалтууд холбогдох засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Хурал, Улсын Их Хурал нь өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд хөндлөнгөөс оролцох боломжийг бүрдүүлсэн байна. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэр хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн эсэх тухай асуудлаар гарсан маргаан нь шүүхийн харъяалан шийдвэрлэх асуудал байх тул Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэстэй байна.” хэмээн үзэж

***Дүгнэлтийн тогтоох хэсгийн 1 дэх заалтад:*** “...Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн “... , эсхүл дээд шатны...” гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн “Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй

болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна." хэмээн заасан.

***Дөрөв. Үндсэн хуулийн цэциин дээрхи дүгнэлтийг Улсын Их Хурал 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 29 дүгээр тогтоол гаргасан байна. Уг тогтоолын 2 дахь заалтад:***

"Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "... , эсхүл дээд шатны..." гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэсэн хэсгийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэсэн байна.

***Тав. Үндсэн хуулийн цэциин их суудлын хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

"... 1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгээр тодорхойлж буй фактын нөхцөл /гипотез/ нь "хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол" гэж байх бөгөөд энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "бүрэн эрхт", Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "нэгдмэл улс"-ынх нь хувьд, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2, 7, 8 дахь заалтад заасан Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх, Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлд заасан Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн дагуу хууль тогтоомжийн нэг тогтолцоо, Засгийн газрын нэг бодлоготой байлгахад чиглэсэн зохицуулалт байна.

Нөгөөтэйгүүр, энэ зохицуулалт нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Ардчилсан ёс, ...хууль дээдлэх зарчим", Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "...засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ", Хорьдугаар зүйлд заасан "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална" гэсэн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

2. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 25.5 дахь хэсгүүдийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэхдээ дурдсан Үндсэн хуулийн заалт нь Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах эрхийг нь хязгаарлах буюу түүнтэй зөрчилдсөн утга бүхий заалт биш байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нутгийн өөрөө уд рдах байгууллага тухайн ...нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулах талаар тодорхойлж өгсөн байгаа нь "хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй" шийдвэр гаргах эрхтэй тухай бус харин ч хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үүргийг хүлээсэн байна. Мөн зүйлийн 2 дахь хэсгийн хоёрдугаар өгүүлбэрт "Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно" гэж хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрээс гадуур байх эрх мэдлийг тусгайлан тодорхойлсон байна. Үндсэн хуулийн эдгээр заалтаас үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллагад хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэрийг зөрчсөн шийдвэр гаргах эрх мэдэл олгогдоогүй байх бөгөөд энэ асуудлыг хянан шалгаж шийдэх эрх мэдэл нь Улсын Их Хуралд Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн зохих хэсгүүдээр олгогдсон байна.

3. Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэр болох "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно" гэсэн зохицуулалтын "дээд шатны байгууллага нь" гэх ойлголтод Улсын Их

Хурлыг хамруулан ойлгох бололцоогүй байна. Нөгөөтэйгүүр, "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудалд" тухайн … нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомж болон Засгийн газрын шийдвэр үйлчлэх эсэх асуудлыг мэдэн шийдэх эрх багтахгүй байна.

4. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Улсын Их Хурал, Засгийн газрын хооронд гарсан маргааныг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд дурдсанчлан шүүх /захиргааны, иргэний, эрүүгийн шүүхийн журмаар/ харъяалан шийдэх боломжгүй байна. Харин Улсын Их Хурлын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хандах байдлаар шийдүүлэх нь нээлттэй байгаа тул Улсын Их Хурал нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох нь тэдний Цэцэд өргөдөл гаргах эрхийг нээж өгсөн зохицуулалт болж байна" гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "… , эсхүл дээд шатны…" гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даах шийдвэрлэх…"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно…" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар дүгнэлт үндэслэлтэй байна.

Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох нь аливаа эрх зүйн маргааныг шүүхээр шийдвэрлэх зарчимтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, Үндсэ[н] хуул[ий]н у[лсын] маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2; 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "… , эсхүл дээд шатны…" гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даах шийдвэрлэх…", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно…" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байх тул Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн "… , эсхүл дээд шатны…" гэсэн заалт, тус зүйлийн 25.5 дахь хэсгийн "Аймаг, нийслэлийн Хурлын шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрт нийцээгүй бол түүнийг Улсын Их Хурал өөрчлөх буюу хүчингүй болгох эрхтэй" гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2009 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн "Үндсэн хуулийн цэцийн 2009 оны 02 дугаар дүгнэлтийн тухай" 29 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хүчингүй болгосугай.

3. Энэхүү тогтоол гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ** **Ж.БЯМБАДОРЖ**

**ГИШҮҮД** **Н.ЖАНЦАН**
**П.ОЧИРБАТ**
**Ж.БОЛДБААТАР**
**Д.НАРАНЧИМЭГ**
**Ц.САРАНТУЯА**
**Д.МӨНХГЭРЭЛ**
**Б.ПҮРЭВНЯМ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон-128 тоот

☎ 262420, 329612
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 4